

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2007 ОНЫ ЭЦСИЙН НЭГТГЭЛИЙН СУДАЛГААНЫ
ТАНИЛЦУУЛГА**


2008.04.01

Улаанбаатар хот

НЭГ. ББСБ-ЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Тайлант жилд шинээр 10 ХХК-нд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооны тогтоолоор олгож, харин нэр бүхий 12 ББСБ ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооны тогтоолоор хүчингүй болгосноор нийт 137 ББСБ ХХК-ийн санхүүгийн тайлан 2007 оны нэгтгэлд хамрагдлаа.


Эдгээрээс үйл ажиллагаагаа 3 ба түүнээс дээш улирал явуулаагүй, ирүүлбэл зохих санхүүгийн тайлан мэдээг холбогдох хууль, журмын дагуу ирүүлээгүй 14 ББСБ ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооны 2007 оны 177, 196 дугаар тогтоолоор тус тус 3 сарын хугацаатайгаар түдгэлзүүлсэн.



Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээг нийт ББСБ-уудын эрхэлж буйгаар нь ангилахад дараах байдалтай байна. Үүнд:

- зээлийн үйл ажиллагаа 134 ББСБ,
- факторингийн үйлчилгээ 6 ББСБ,
- санхүүгийн түрээсийн үйлчилгээ 12 ББСБ,
- төлбөрийн баталгаа гаргах 4 ББСБ,
- төлбөр тооцооны хэрэгсэл гаргах 1 ББСБ,
- цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ 9 ББСБ,
- гадаад валютын арилжааны үйл ажиллагаа 52 ББСБ,
- итгэлцлийн үйлчилгээ 13 ББСБ,
- богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх 2 ББСБ,
- хөрөнгө оруулалт, санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ 4 ББСБ,

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий ББСБ ХХК-уудыг дүрмийн сангийн хэмжээгээр нь ангилахад дараах байдалтай байна.



Орон нутагт 25 ББСБ ХХК үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-уудын 18.2 хувийг, тэдгээрийн нийт актив 2,169.4 сая төгрөг байгаа нь нийт ББСБ-уудын активын 3.3 хувийг, нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 1,513.5 сая төгрөг байгаа нь нийт ББСБ-уудын олгосон зээл, түүнтэй адилтган тооцох активын 4.3 хувийг тус тус эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-дын байршлын хувьд авч үзвэл Дорнод аймагт 7, Орхон аймагт 3, Дархан-Уул, Хөвсгөл, Төв зэрэг аймгуудад тус бүр 2, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Говь-Алтай, Увс, Архангай, Баянхонгор, Хэнтий, Дорноговь зэрэг аймгуудад тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

Гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 14 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 10.2 хувийг, тэдгээрийн нийт актив 11,646.6 сая төгрөгт хүрсэн нь ББСБ-ын нийт активын 17.5 хувийг, нийт олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив 3,769.9 сая төгрөг байгаа нь нийт ББСБ-уудын олгосон зээл, түүнтэй адилтган тооцох активын 10.6 хувийг тус тус эзэлж байна.

Харьяалалаар нь авч үзвэл, Дэлхийн Зөн Олон улсын байгууллагаас санхүүжигдсэн 1 /Зөн сан Монгол/, Япон улсын хөрөнгө оруулалттай 4 /Тэнхлэг финанс, Мариико, Сар шинэ интернейшнл, Цагаан ажнай/, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын хөрөнгө оруулалттай 1 /Ийст Уэст факторинг/, БНХАУ, БНСУ болон Италийн 100 хувийн ба хамтарсан хөрөнгө оруулалттай 8 /Грасслэнд, Футур эволюшн, Би И Ай/ ББСБ үйл ажиллагаа явуулж байна. /Хавсралт 3/

Иргэний хуулийн 27.1, 27.3, 36.2 дахь хэсэгт тус тус заасныг удирдлага болгон Хорооноос 2006 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 26 дугаар тогтоолоор банк бус санхүүгийн байгууллагын оноосон нэрэнд “сан” гэдэг үг орохыг хориглосон шийдвэр гаргасантай холбоотойгоор 9 ББСБ оноосон нэрээ өөрчилжээ.

Түүнчлэн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ шинэчлэн олгох ажлын хүрээнд Монголбанкнаас банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаа явуулж байгаа 132 ББСБ ХХК байснаас 2007 онд 109 ББСБ ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинэчлэн олгосон.

Тайлант онд Улаанбаатар хот болон орон нутаг дахь ББСБ-ын нийт салбар, нэгжийн тоо 43, нийт хувь нийлүүлэгчдийн тоо 433, нийт ажиллагсдын тоо 647 гаруйд хүрсэн ба давхардсан тоогоор 72.9 мянга гаруй харилцагчдад санхүүгийн үйлчилгээг үзүүлжээ.

Судалгаанаас үзэхэд ББСБ-уудын олгож буй зээлийн хүүгийн түвшин дундажаар 2.0-3.5 хувь, бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэрт төлж буй хүүгийн түвшин дундажаар 0.5-2.0 хувь байна.

ХОЁР. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Тайлант хугацаанд нийт эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар буурсан ч, хүүгийн орлого авчирдаг актив 30,958.9-35,402.4 сая төгрөг болж өссөнтэй холбоотойгоор нийт орлого өмнөх оны мөн үеэс **/өмнөх оны мөн үед нийт орлого 9,084.4 сая төгрөг/** 52.0 хувь буюу 4,728.7 сая төгрөгөөр өсч 13,812.4 сая төгрөгт хүрчээ.

Нийт орлогын 60.2 хувийг зээлийн хүүгийн орлого эзэлж байгаа нь ББСБ-уудын хувьд зээлийн үйл ажиллагааны орлого нь нийт орлогын гол эх үүсвэр болсоор байгааг, түүнчлэн гадаад валютын арилжааны болон ханшийн тэгшитгэлийн орлого нийт орлогын 27.5 хувийг эзэлж байгаа нь гадаад валютын арилжааны үйл ажиллагааг ББСБ-ууд идэвхитэй эрхэлж байгааг тус тус харуулж байна.

Нийт зардал өмнөх оны мөн үеэс **/өмнөх оны мөн үед нийт зардал 7,791.5 сая төгрөг/** зардал зүйл тус бүрээр өссөнөөр, нийт зардал 42.6 хувь буюу 3,319.2 сая төгрөгөөр өсч 11,110.7 сая төгрөгт хүрчээ.

Нийт зардлын өсөлтийн шалтгаан нь нэгдүгээрт, ББСБ-уудад итгэлцлийн үйлчилгээгээр санхүүгийн эх үүсвэр бусдаас татан төвлөрүүлж байгаа, банк, санхүүгийн байгууллагаас зээл авах хандлага нэмэгдсэн, дамжуулан зээлдүүлэх төсөлд хамрагдах ББСБ-уудын тоо өссөн зэрэг обьектив хүчин зүйлээс шалтгаалж хүүгийн зардал өссөн **/зээлийн хүүгийн зардал нийт зардлын 8.1 хувь/**, хоёрдугаарт, үйлчилгээний цар хүрээ өргөжсөнтэй холбоотойгоор үйл ажиллагааны бусад **/нийт зардлын 27.3 хувь/** болон боловсон хүчинтэй холбоотой зардал нэмэгдсэн **/нийт зардлын 16.4 хувь/**, гурвдугаарт, зээл болон зээлтэй адилтган тооцох активын хэмжээ нэмэгдсэн, активын чанар муудаж байгаагаас эрсдлийн зардал өссөн **/нийт зардлын 6.7 хувь/**, дөрөвдүгээрт, гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалж ханшийн тэгшитгэлийн зардал, гадаад валютын арилжаанаас хүлээх алдагдал **/нийт зардлын 32.1 хувь/** нэмэгдсэн зэрэгтэй тус тус холбоотой байна.


ББСБ-ууд нийт 2,701.7 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **/өмнөх оны мөн үеийн цэвэр ашиг 1,192.8 сая төгрөг/** 2.3 дахин өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь ББСБ-уудын үйл ажиллагааны цар хүрээ өсч, бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэр нэмэгдэн, санхүүгийн зуучлалын хүрээ өргөжсөнтэй холбоотойгоор нийт орлого өссөн, өөрөөр хэлбэл, нийт орлогын өсөлтийн хурдац нийт зардлын өсөлтийн хурдацаас их байгааг харуулж байна.

Тайлант хугацаанд тодорхой хэмжээгээр ашигтай ажилласан 112 ББСБ байгаа нь нийт ББСБ-ын 81.8 хувийг эзэлж байгаа ба тэдгээрийн ашиг 19.7 мянган төгрөгөөс 372.7 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. Харин 19 ББСБ буюу нийт ББСБ-уудын 13.9 хувь нь 70.9 мянган төгрөгөөс 288.3 сая төгрөг хүртэл алдагдалтай ажилласан байна.

ББСБ-уудын орлого, зардал болон нийт ашиг, алдагдлын тоон үзүүлэлтүүдийг он дарааллаар харуулахад дараах байдалтай байна.

төгрөгөөр/

/мянган



Түүнчлэн ББСБ-ууд нийт 1,333.9 сая төгрөгийн ашгийг хуримтлуулан тооцсон буюу хуваарилагдаагүй ашиг байна.

ГУРАВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Активын өөрчлөлтийн талаар

ББСБ-уудын тайлант оны нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:


		/мянган төгрөгөөр/					
	ХӨРӨНГӨ	2007/12/31	хувь	2006/12/31	хувь	өөрчлөлт	хувь
A	Эргэлтийн хөрөнгө	61,555,559.7	92.6%	57,296,667.2	82.8%	4,258,892.49	9.8%
1	Мөнгөн хөрөнгө	17,907,111.2	27.0%	19,078,150.8	27.6%	(1,171,039.5)	0.6%
2	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалт /цэврээр/	4,331,695.7	6.5%	4,156,147.8	6.0%	175,547.8	0.5%
3	Зээл /цэврээр/	34,141,791.2	51.4%	29,381,548.0	42.5%	4,760,243.1	8.9%
	<i>(Зээлийн эрсдлийн сан)</i>	1,253,126.1	1.9%	1,136,488.2	1.6%	116,637.9	0.2%
4	Санхүүгийн түрээсийн тооцооны авлага /цэврээр/	7,122.6	0.0%	372,633.5	0.5%	(365,510.9)	0.5%
	<i>(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)</i>	0.0	0.0%	25,523.7	0.0%	(25,523.7)	0.0%
5	Факторингийн тооцооны авлага /цэврээр/	0.0	0.0%	41,045.6	0.1%	(41,045.6)	0.1%
	<i>(Факторингийн</i>	350.0	0.0%	1,619.5	0.0%	(1,269.5)	0.0%

Санхүүгийн зохицуулах хороо

	авлагын эрсдлийн сан)						
6	Санхүүгийн деривативын авлага	0.0	0.0%	10,710.0	0.0%	(10,710.0)	0.0%
7	Бусад актив	4,327,333.4	6.5%	3,553,296.7	5.1%	774,036.7	1.4%
	Авлага /цэврээр/	1,381,667.8	2.1%	1,150,723.4	1.7%	230,944.4	0.4%
	(Авлагын болзошгүй эрсдлийн сан)	11,717.5	0.0%	23,405.7	0.0%	(11,688.1)	0.0%
8	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	840,505.7	1.3%	703,134.8	1.0%	137,370.9	0.2%
Б	Эргэлтийн бус хөрөнгө	4,887,355.2	7.4%	11,904,231.7	17.2%	(7,016,876.5)	-
9	Өмчлөх хөрөнгө /цэврээр/	316,636.8	0.5%	264,196.8	0.4%	52,439.9	0.1%
	Өмчлөх бусад хөрөнгө	435,106.9	0.7%	365,773.6	0.5%	69,333.3	0.1%
	(Болзошгүй эрсдлийн сан)	118,470.1	0.2%	101,576.8	0.1%	16,893.3	0.0%
10	Үндсэн хөрөнгө /цэврээр/	4,570,718.5	6.9%	11,640,034.9	16.8%	7,069,316.4	9.9%
	Үндсэн хөрөнгө	5,454,739.7	8.2%	12,395,356.8	17.9%	(6,940,617.1)	9.7%
	(Хуримтлагдсан элэгдэл)	884,021.2	1.3%	755,321.9	1.1%	128,699.3	0.2%
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	66,442,914.9	100.0%	69,200,898.9	100.0%	(2,757,984.0)	0.0%

Нийт эх үүсвэр буурсантай холбоотойгоор нийт актив өмнөх оны мөн үеэс 4.2 хувь буюу 2,757.9 сая төгрөгөөр буурсан ба нийт активын бүтцэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлтүүд орсон байна. Тухайлбал, хүүгийн орлого авчирдаг активуудын дүн 30,958.9-35,402.4 сая төгрөг болж өссөнөөр нийт активт эзлэх хувийн жин нь 44.8-53.3 хувь болж өссөн. Энэ нь орлого авчирдаг активын өсөлтийн хурдац нь нийт активын өсөлтийн хурдацаас их байгаатай холбоотой. Харин ББСБ-уудын үндсэн хөрөнгийн хэмжээ 2.6 дахин буурсантай холбоотойгоор эргэлтийн бус хөрөнгийн нийт активт эзлэх хувийн жин 17.2-7.4 хувь болж буурсан байна.

ББСБ-уудыг нийт активын хэмжээгээр нь ангилахад дараах байдалтай байна.



3.2 Активын багцын чанар

ББСБ-ууд зээлийн идэвхтэй үйл ажиллйгаа явуулсантай холбоотойгоор зээл, түүнтэй адилтгах актив */хүүгийн орлого авчирдаг актив/* өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар буюу 4,443.5 сая төгрөгөөр өсч 35,402.4 сая төгрөгт хүрсэн нь нийт активын 53.3 хувийг эзэлж байна.

Зээл, түүнтэй адилтгах активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

		<i>/мянган төгрөгөөр/</i>					
	Актив	2007.12.31	Хувь	2006.12.31	Хувь	Өөрчлөлт	Хувь
1	Хэвийн зээл	32,655,206.72	92.2	28,202,238.29	91.1	4,452,968.4	1.1
2	Хугацаа хэтэрсэн зээл	1,194,371.50	3.4	1,059,537.32	3.4	134,834.2	-0.0
3	Чанаргүй зээл. Үүнээс:	1,545,339.06	4.4	1,256,260.64	4.1	289,078.4	0.3
	а/ Хэвийн бус	325,873.92	0.9	320,674.01	1.0	5,199.9	-0.1
	б/ Эргэлзээтэй	537,922.94	1.5	157,614.68	0.5	380,308.3	1.0
	в/ Муу	681,542.20	1.9	777,971.94	2.5	-96,429.7	-0.6
4	Хэвийн санхүүгийн түрээс	7,071.95	0.0	329,810.28	1.1	-322,738.3	-1.0
5	Хугацаа хэтэрсэн санхүүгийн түрээс	50.60	0.0	0.00	0.0	50.6	0.0
6	Чанаргүй санхүүгийн түрээс. Үүнээс:	0.00	0.0	68,346.88	0.2	-68,346.9	-0.2
	а/ Хэвийн бус	0.00	0.0	54,511.63	0.2	-54,511.6	-0.2
	б/ Эргэлзээтэй	0.00	0.0	0.00	0.0	0.0	0.0
	в/ Муу	0.00	0.0	13,835.25	0.0	-13,835.2	-0.0
7	Хэвийн факторинг	0.00	0.0	42,315.00	0.1	-42,315.0	-0.1
8	Хугацаа хэтэрсэн факторинг	0.00	0.0	0.00	0.0	0.0	0.0
9	Чанаргүй факторинг	350.00	0.0	350.00	0.0	0.0	-0.0
	НИЙТ	35,402,389.84	100.0	30,958,858.42	100.0	4,443,531.4	0.0

Нийт хэвийн болон чанаргүй зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 4,452.9 сая болон 289.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн ч нийт зээл, түүнтэй адилтгах активын өсөлтийн хурдацтай ойролцоо байгаагаас түүнд эзлэх хувийн жин бага зэрэг буюу 1.1 болон 0.3 хувиар тус тус өссөн, харин хугацаа хэтэрсэн зээл 134.8 сая төгрөгөөр өссөн ч нийт зээл, түүнтэй адилтгах активын өсөлтийн хурдацтай тэнцүү байгаагаас түүнд эзлэх хувийн жинд өөрчлөлт ороогүй байна. Харин бусад ангилалын зээлийн өрийн үлдэгдэл буурсан үзүүлэлттэй байна.

Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хууль 2006 онд батлагдаж, ББСБ-ууд санхүүгийн түрээсийн үйлчилгээг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэхээр хуульчлагдсанаар санхүүгийн түрээсийн үйлчилгээг дангаар эрхлэж байсан ББСБ, тухайлбал Монгол лизинг ХХК банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө хүчингүй болгуулснаар ББСБ-ын 2007 оны жилийн эцсийн нэгтгэлийн танилцуулга

санхүүгийн түрээсийн үйлчилгээний өрийн үлдэгдэл 322.7 сая төгрөгөөр, харин факторингийн үйлчилгээний цар хүрээ өргөжихгүй байгаагаас факторингийн үйлчилгээний үлдэгдэл 42.3 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ТАЛААР

4.1 Нийт эх үүсвэрийн өөрчлөлтийн талаар

ББСБ-уудын тайлант оны нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна.

		/мянган төгрөгөөр/					
	ӨР ТӨЛБӨР	2007/12/31	Хувь	2006/12/31	Хувь	өөрчлөлт	хувь
A	Санхүүгийн бусад эх үүсвэр	12,044,627.7	18.1%	20,175,706.1	29.2%	8,131,078.4	11.0%
1	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	4,161,907.5	6.3%	12,298,604.0	17.8%	8,136,696.5	11.5%
2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хугацаа хэтрэлт	469,773.2	0.7%	0.0	0.0%	469,773.2	0.7%
3	Бусад эх үүсвэр	3,842,262.4	5.8%	4,784,253.6	6.9%	-941,991.2	-1.1%
	Итгэлцлийн үйлчилгээний тооцооны өглөг	2,557,890.8	3.8%	3,340,997.4	4.8%	-783,106.5	-1.0%
	Факторингийн тооцооны өглөг	0.0	0.0%	293,000.0	0.4%	-293,000.0	-0.4%
	Мөнгөн гуйвуулга, төлбөр тооцооны өглөг	1,284,371.6	1.9%	1,150,256.2	1.7%	134,115.4	0.3%
4	Санхүүгийн деривативын өглөг	0.0	0.0%	38,657.3	0.1%	-38,657.3	-0.1%
5	Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	19,045.7	0.0%	43,803.5	0.1%	-24,757.8	0.0%
6	Төслийн зээлийн санхүүжилт	3,551,638.9	5.3%	3,010,387.7	4.4%	541,251.2	1.0%
Б	Бусад өр төлбөр	6,324,833.1	9.5%	1,304,480.8	1.9%	5,020,352.3	7.6%
7	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	294,705.1	0.4%	143,736.9	0.2%	150,968.2	0.2%
8	Бусад пассив	6,030,127.9	9.1%	1,160,743.9	1.7%	4,869,384.1	7.4%
	Нийт өр төлбөр	18,369,460.8	27.6%	21,480,187.0	31.0%	3,110,726.1	-3.4%
9	Өөрийн хөрөнгө	48,073,454.1	72.4%	47,720,711.9	69.0%	352,742.1	3.4%
	Ердийн хувьцаа	41,729,859.5	62.8%	43,463,714.7	62.8%	1,733,855.2	0.0%
	Давуу эрхтэй хувьцаа	44,850.0	0.1%	30,010.0	0.0%	14,840.0	0.0%
	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	454,013.8	0.7%	785,597.1	1.1%	-331,583.3	-0.5%
	Дахин үнэлгээний нэмэгдэл	11,496.5	0.0%	73,877.8	0.1%	-62,381.3	-0.1%
	Нөөцийн сан	1,085,647.3	1.6%	1,073,776.0	1.6%	11,871.3	0.1%
	Нийгмийн хөгжлийн сан	21,271.3	0.0%	50,797.8	0.1%	-29,526.4	0.0%
	Хувь нийлүүлэгчдийн өмчийн бусад хэсэг	690,784.7	1.0%	312,974.9	0.5%	377,809.8	0.6%
	Тухайн үеийн ашиг/алдагдал	2,701,675.4	4.1%	1,294,411.1	1.9%	1,407,264.3	2.2%
	Хуримтлагдсан	1,333,855.4	2.0%	635,552.5	0.9%	698,302.9	1.1%

	ашиг/алдагдал						
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	66,442,914.9	100.0%	69,200,898.9	100.0%	-	0.0%
						2,757,984.0	

ББСБ-уудын банкнаас авсан зээлийн хэмжээ 3 дахин буюу 8,136.7 сая төгрөгөөр, ердийн хувьцаа 4.2 хувь буюу 1,733.9 сая төгрөгөөр тус тус буурсанаар тайлант хугацаанд нийт эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар буурсан ба нийт эх үүсвэрийн бүтцэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлтүүд орсон. Тухайлбал, итгэлцлийн үйлчилгээний болон факторингийн тооцооны өглөг буурсанаар бусад эх үүсвэрийн нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин 6.9-5.8 хувь болж буурсан, харин өөрийн хөрөнгийн хэмжээ тухайн үеийн ашгийн түвшингийн өсөлтөөс шалтгаалж нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин нь 69.0-72.4 хувь болж өссөн байна. Энэ нь ББСБ-уудын өөрийн хөрөнгийн өсөлтийн хурдац нь нийт эх үүсвэрийн өсөлтийн хурдацаас их байгаатай холбоотой.

Нийт эх үүсвэрийн 72.4 хувийг өөрийн хөрөнгөөр бүрдүүлж байгаа нь бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх явц нь зохистой түвшинд байгааг харуулж байна.

ТАВ. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

ББСБ-ын нэгтгэлийн хувьд Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 56 тоот тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох тухай журам”-аар тогтоосон зохистой харьцааны дараах шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна.

- нийт өөрийн хөрөнгө **48,052.2** сая төгрөг, эрсдлээр жигнэсэн актив **48,535.8** сая төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хувьд **96.53** хувь, нийт өөрийн хөрөнгийн хувьд **99.00** хувь байгаа нь тус үзүүлэлтүүдийг хангасан.


- түргэн борлогдох актив **17,907.1** сая төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө **15,384.1** сая төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа **116.4** хувь байгаа нь тус үзүүлэлтийг хангасан.

- Гадаад валютаар олгосон зээлийн өрийн үлдэгдэл, касст байгаа бэлэн валют, банкин дахь валютын харилцах дансан дахь үлдэгдэл нийт **11,899.3** сая төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө **2,779.6** сая төгрөг байгаагаас гадаад валютын ханшийн эрсдлийн зохистой харьцаа нь **18.98** хувь байгаа нь тус үзүүлэлтийг хангасан.

Харин активын эрсдлийн санг Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүү, эдийн засгийн сайдын 2004 оны 459/207 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу **1,364.8** сая төгрөгөөр байгуулахаас **1,383.7** сая төгрөгөөр буюу **18.9** сая төгрөгөөр илүү байгуулсан,

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

Тайлант жилийн ББСБ-уудын нийт актив болон өөрийн хөрөнгийн өсөлтийг өмнөх жилүүдтэй харьцуулахад дараах байдалтай байна.



ББСБ-уудын нийт актив 2007 оны эцсээр байдлаар 66,442.9 сая төгрөг байгаа нь банкны салбарын нийт активын /**банкны салбарын нийт актив 3,278,763.5 сая төгрөг**/ 2.0 хувьтай, харин Монгол Улсын 2007 оны эцсээрх дотоодын нийт бүтээгдэхүүний /**4,557.5 тэрбум төгрөг**/ 1.5 хувьтай тус тус тэнцэж байгаа ба нийт активын өгөөж 4.6 /ROA/ хувь байна.

Өөрийн хөрөнгө 48,073.5 сая төгрөгт хүрсэн нь нийт банкны салбарын эзэмшигчдийн өмчийн /**эзэмшигчийн өмч 376,632.9 сая төгрөг**/ 12.8 хувьтай тэнцэж байгаа бөгөөд өөрийн хөрөнгийн өгөөж 6.1 /ROE/ хувь байна.

ББСБ-уудын нийт олгосон зээл, түүнтэй адилтгах активын хэмжээ 35,402.4 сая төгрөг байгаа банкны салбарын нийт олгосон зээлийн /**2,114,549.9 сая төгрөг**/ 1.67 хувьтай тэнцэж байна.

ББСБ-уудын активын чанар системийн хэмжээгээр харьцангуй сайн буюу хүүгийн орлого авчирдаг актив нийт активын 53.3 хувийг эзэлж байгаа, санхүү, төлбөрийн чадварын гол гол үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч байгаа ч ББСБ-уудын санхүүгийн зуучлалд гүйцэтгэж байгаа үүрэг хязгаарлагдмал хэвээр байна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР